



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 5 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 118

Улаанбаатар
хот

Журмын хавсралтыг өөрчлөн
батлах тухай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хавсралтыг энэ тогтоолын хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 105 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Монгол Улсын Шадар сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

С.АМАРСАЙХАН

Засгийн газрын 2021 оны 118 дугаар
тогтоолын хавсралт

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож,
төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг
зохицуулах түр журмын хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Зэрэглэл Түвшин	Өдөр тутмын бэлэн байдал		Өндөржүүлсэн бэлэн байдал		Бүх нийтийн бэлэн байдал	
	I	II	III	IV		
	Халдвар илрээгүй	Зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай	Халдвар голомтот тархалттай	Халдвар хүн амын дунд тархсан		
Төрийн байгууллага	Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах	Уралдаан тэмцээн, аялал зугаалга	Хязгаарлах үйл ажиллагаа			
			<p>1.Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага шүүх, прокурор (нийт ажилтан, албан хаагчийн 30 хувь хүртэл ажиллах, цагийн хязгаар тогтоох), иргэдэд үйлчилгээ үзүүлдэг нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаа хязгаарлалтад хамаарахгүй;</p> <p>2.Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, цайллага, хүлээн авалт;</p> <p>3.Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ;</p> <p>4.Цахимаар болон зайнаас зохион байгуулахаас бусад соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаа.</p>	<p>Хязгаарлахгүй (тусгай горимоор зохицуулах) үйл ажиллагаа</p> <p>1.Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага шүүх, прокурор (нийт ажилтан, албан хаагчийн 10 хүртэл хувь ажиллах, цагийн хязгаар тогтоох);</p> <p>2.Эрүүл мэндийн байгууллага (ажилдаа ирэх, очих, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үед);</p> <p>3.Тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудын хариу арга хэмжээнд оролцох, дэмжлэг үзүүлэх, томилгоот, жижүүрлэлтийн бүрэлдэхүүнээс бусад ажилтан, алба хаагч цахимаар ажиллах (Байгаль орчныг хамгаалах, гааль, цаг уур, орчны шинжилгээний газар, улсын бүртгэл, дипломат алба, гадаад улсаас Монгол улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчин, хил хамгаалах, дотоодын цэрэг,</p>		

					<p>цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар);</p> <p>4. Сонгуулийн ерөнхий хороо, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудал, “МИАТ” ТӨХК;</p> <p>5. Эрчим хүч, төмөр зам, авто замын засвар, шинэчлэлт, дулаан, инженерийн хангамж, ариутгал, хот, нийтийн аж ахуй;</p> <p>6. Шуудан, харилцаа холбоо;</p> <p>7. Шатахуун, түлшний үйлдвэрлэл, хангамж, нийлүүлэлт, түгээлт, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын түлшний тээвэрлэлт, худалдаа; (Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, тогтоосон цагийн хуваариар);</p> <p>8. Геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт (зөвшөөрөгдсөн нутаг дэвсгэрт);</p> <p>9. Зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамж, түр хамгаалах байр, Монголын улаан загалмай нийгэмлэг;</p> <p>10. Цахим банк, автомат тооцооны машин;</p> <p>11. Газар тариалан (тусгаарлалтын болон халдвар хамгааллын дэглэм сахих), мал, амьтны өвс, тэжээлийн тээвэрлэлт, түгээлт.</p>
--	--	--	--	--	---

Тайлбар: Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг Улсын онцгой комисстой зөвшилцсөнөөр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага

<p>Ажиллах горим</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>Нэг дор 30-аас дээш хүн хязгаарлах, (2 метрээс доошгүй зай барих)</p>	<p>-Ажлын байрны дотоод орчинд нэг дор 10-аас дээш хүн хязгаарлах (2 метрээс доошгүй зай барих);</p> <p>-Нэг өрөөнд 3-аас илүү албан хаагч хамт ажиллахгүй, хооллохгүй байх;</p> <p>-Албан бичиг баримтыг цахимаар хүлээн авах, солилцох.</p>	<p>-Ажилдаа ирэх, явах (Зөвхөн хариу арга хэмжээнд оролцох, томилгоот ажил үүрэг гүйцэтгэх);</p> <p>-Халдвартай тэмцэх, хариу арга хэмжээ авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагчдын хоол үйлдвэрлэл, түгээлт (аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтоосон горимоор);</p> <p>-Төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжийн ажил, үүрэг гүйцэтгэх, засвар үйлчилгээ, үйлдвэрлэл, түгээлт;</p> <p>-Бүх яам, агентлаг 24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэх, шуурхай штабын бүрэлдэхүүнийг томилж, Улсын онцгой комиссын Шуурхай</p>
-----------------------------	---	--	---	---

					штабтай мэдээ, мэдээлэл шуурхай солилцож, ажиллана.
Хөдөлгөөнд оролцох цагийн горим	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	06:00-00:00	06:00-22:00 (Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар хөдөлгөөнд оролцох зохицуулалт хийнэ)	Өглөө 07:00-09:00 Орой 17:00-20:00 (Эрчим хүч, дулаан, инженерийн хангамж, ариутгал, хот, нийтийн аж ахуйд хамаарахгүй)	
Нийтийн тээврийн хэрэгсэл	Ердийн цагийн хуваариар	-Ердийн цагийн хуваариар; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.	-Аймаг нийслэлийн Засаг даргын захирамжаар маршрут, чиглэл, цагийн хуваарийн зохицуулалт хийнэ. -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах; -Хяналтын байцаагч ажиллуулах.	-Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тусгайлан заасан чиглэл, маршрут, цагийн хуваарьт шилжүүлэх; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах; -Хяналтын байцаагч ажиллуулах.	
Автомашин	Автомашин	Автомашин	Автомашин	Автомашин	
Хот хоорондын зорчигч тээвэр (төмөр зам, авто зам)	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Ердийн цагийн хуваариар -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.	-Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар автомашин замын хөдөлгөөнд оролцох зохицуулалт хийнэ.	-Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагч байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхтэй (аймгийн нутаг дэвсгэрт); -Цахим хэлбэрээр "QR" код бүртгэлжүүлж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих (нийслэлийн нутаг дэвсгэрт).	
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.	-Улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын зөвшөөрөлтэй; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.	-Улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын зөвшөөрөлтэй; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахиулах.	
Агаарын хил, авто зам, төмөр замын боомт	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.	-Албан томилолт, зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгслийг улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр нэвтрүүлэх.	-Албан томилолт, зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгслийг улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр нэвтрүүлэх.	

		албан айлчлал, уулзалт, арга хэмжээний төлөөлөгчид, хувийн хэвшлийн шугамаар зайлшгүй ирэх шаардлагатай зохих ангиллын виз, зөвшөөрөлтэй гадаадын иргэний хөдөлгөөнийг Улсын онцгой комиссын шийдвэрээр зөвшөөрөх	
<p>Ажлын байрны горим</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>-Халдвар хамгааллын дэглэм сахих; -Байгууллага дээр "QR" код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх.</p>	<p>-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Ажилчдын ажилд ирэх, явах, цайны цагийг зөрүүлэх; -Халдвар хамгааллын дэглэм сахиулан ажиллах; -Байгууллага дээр "QR" код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.</p>

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Зэрэглэл	Өдөр тутмын бэлэн байдал	Өндөржүүлсэн бэлэн байдал		Бүх нийтийн бэлэн байдал
Түвшин	Халдвар илрээгүй	II Зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай	III Халдвар голомтот тархалттай	IV Халдвар хүн амын дунд тархсан
		Хязгаарлах үйл ажиллагаа:		Хязгаарлахгүй (тусгай горимоор зохицуулах) үйл ажиллагаа
Хуулийн этгээд	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэд мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэм сахих	<p>1.Жагсаал, цуглаан, уралдаан тэмцээн;</p> <p>2.Аялал зугаалга, хурим найр; цайллага, хүлээн авалт;</p> <p>3.Бүх төрлийн баар;</p> <p>4.Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар (Ресторан, кафе, сүлжээ хоолны газар, түргэн хоолны газар, кофе шоп, цайны газар, буфет, явуулын үйлчилгээтэй хоолны газар) нь үйлчилгээний танхим болон гадна талбайд үйлчилгээ явуулахыг хязгаарлах, захиалгат болон хүргэлтийн хоолны үйлчилгээг зөвшөөрнө;</p> <p>5.Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа;</p> <p>6.Хүнснээс бусад барааны зах, худалдааны төв (Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", тусгай нөхцөл шаардлага, бэлтгэл ажлыг</p>		<p>1.Эрчим хүч, дулаан, усан хангамж (тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр);</p> <p>2.Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага;</p> <p>3.Шатахуун, түлшний хангамж;</p> <p>4.Хүнс, ахуйн барааны үйлдвэрлэл, сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, тээвэр зуучийн үйл ажиллагаа;</p> <p>5.Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, цуглуулалт, тээвэрлэлт;</p> <p>6.Цахим банк, автомат тооцооны машин;</p> <p>7.Газар тариалан (тухайн байршилдаа тусгаарлалтын болон халдвар, хамгааллын дэглэм мөрдөх), өвс тэжээл, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа;</p> <p>8.Харилцаа холбоо, шуудан илгээмж;</p> <p>9.Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа (эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр);</p> <p>10.Хэвлэл мэдээлэл;</p>

			<p>хангасан нөхцөлд үйл ажиллагааг үе шаттай нээж явуулахыг зөвшөөрнө);</p> <p>7.Цахим, автомат тоглоомын газар, бүх төрлийн тоглоомын төв;</p> <p>8.Сургалтын төв;</p> <p>9.Соёл урлагийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээ;</p> <p>10.Алжаал тайлах төв;</p> <p>11.Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв;</p> <p>12.Саун, бассейн, нийтийн халуун ус;</p> <p>13.Зочид буудал, дэн буудал;</p> <p>14.Амралт, жуулчны газар;</p> <p>15.Шашны зан үйл, сүм, хийд, мөргөлийн газрууд;</p> <p>16.Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ;</p> <p>17.Хүүхдийн тоглоомын болон сагс, хөл бөмбөгийн талбай;</p> <p>18.Нийтийн бүжиг ба бүх төрлийн бүжгийн клуб.</p>	<p>11.Өмгөөлөл, нотариат;</p> <p>12.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага (48 цагт нэг удаа ээлж солилцох);</p> <p>13.Геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт, зам, барилга, арьс шир;</p> <p>14.Орон сууц, нийтийн үйлчилгээний контор, сууц өмчлөгчдийн холбоо;</p> <p>15.Оршуулгын үйл ажиллагаа.</p>
<p>Тайлбар: Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг Улсын онцгой комисстой зөвшилцсөнөөр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.</p>				
<p>Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага</p>				
<p>Ажлын горим</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>Нэг дор 30-аас дээш хүнийг хязгаарлах. (2 метрээс доошгүй зай барих)</p>	<p>-Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", тусгай нөхцөл шаардлага, мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмжийг дагаж мөрдөнө.</p>	
<p>Коронавируст /КОВИД-19 халдварын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн нотлох баримт, Коронавируст /КОВИД-19/ халдвараар өвчилж эдгэсэн эрүүл мэндийн байгууллагын магадлагаатай байна.</p>				

	(Хязгаарлалт тогтоосноос бусад үйл ажиллагаа явуулах худалдаа, үйлчилгээ эрхлэгч нь нотлох баримтыг ажлын байранд цахим болон цаасан хэлбэрээр байршуулсан байх). Дархлаажуулалтын тухай хуулийн 7.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажилчдыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлэх.			Өглөө 07:00-10:00 Орой 17:00-20:00
Хөдөлгөөнд оролцох цагийн хязгаарлалт	Хэвийн	06:00-00:00	06:00-22:00 (Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар зохицуулалт хийнэ)	(Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эрчим хүч, дулаан, усан хангамж, орон сууц, хог хаягдал, халдваргүйтгэл, хүнс, түлшнийүйлдвэрлэл, түгээлтийн үйл ажиллагаанд тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл цагийн хязгаарлалтгүй, бусад хүнс түгээлт гарагийн зохицуулалттайгаар хөдөлгөөнд оролцоно)
Хот дотор нийтийн тээврийн хэрэгсэл	Ердийн цагийн хуваариар	-Ердийн цагийн хуваариар; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Тусгай цагийн хуваариар; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Онцгой комиссын зөвшөөрсөн чиглэлд; -Цагийн хуваарийг тусгай горимд шилжүүлэх; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Автомашин	-Автомашин хязгаарлалтын нийслэлд)	улсын дугаарын дагуу зорчих (зөвхөн нийслэлд)	-Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар автомашин замын хөдөлгөөнд оролцох зохицуулалт хийнэ.	-Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхтэй (аймгийн нутаг дэвсгэрт); -Цахим хэлбэрээр "QR" код бүртгэлжүүлж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих (нийслэлийн нутаг дэвсгэрт).
Хот хоорондын авто болон төмөр зам, агаарын зорчигч тээвэр	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.	-Онцгой комиссын зөвшөөрөлтэй; -1 суудал алгасч 1 зорчигч суулгах; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Шардлагатай тохиолдолд асуумж авч нэвтрүүлэх	-Орох гарах тээврийн хэрэгслийг хязгаарлах; -Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх.	Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх.
	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.			

Олон улсын болон дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг хязгаарлахгүй.

<p>Агаарын хил, авто, төмөр замын боомт</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>-Халдвар хамгааллын дэглэм сахих; -“QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх. -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах;</p>	<p>-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Ажилчдын ажилд ирэх, явах, цайны цагийг зөрүүлэх; -Халдвар хамгааллын дэглэм сахиулж, түүнд хяналт тавих ажилтныг томилгоожуулах; -“QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах.</p>	<p>-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Байгууллага дээр “QR” код байршуулан ажилтан, албан хаагч, зайлшгүй шаардлагаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.</p>
<p>Ажлын байрны горим</p>	<p>Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)</p>	<p>-Халдвар хамгааллын дэглэм сахих; -“QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх. -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах;</p>	<p>-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Ажилчдын ажилд ирэх, явах, цайны цагийг зөрүүлэх; -Халдвар хамгааллын дэглэм сахиулж, түүнд хяналт тавих ажилтныг томилгоожуулах; -“QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах.</p>	<p>-Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); -Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах; -Байгууллага дээр “QR” код байршуулан ажилтан, албан хаагч, зайлшгүй шаардлагаар үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх; -Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах; -Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах; -Халдвар хамгааллын дэглэм сахих.</p>

ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Зэрэглэл	Өдөр тутмын бэлэн байдал		Өндөржүүлсэн бэлэн байдал		Бүх нийтийн бэлэн байдал
	I	II	III	IV	
Түвшин	Халдвар илрээгүй	Зөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай	Халдвар голомтот тархалттай		Халдвар хүн амын дунд тархсан
			Хязгаарлах үйл ажиллагаа	Хязгаарлах үйл ажиллагаа	Хязгаарлахгүй (тусгай горимоор зохицуулах) үйл ажиллагаа
Хүн	Иргэд мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэм сахих	1. Уралдаан тэмцээн; 2. Аялал зугаалга (гэр бүлээс бусад); 3. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 4. Цахим тоглоомын газар, хүүхдийн тоглоомын төв.	1. Жагсаал, цуглаан, уралдаан тэмцээн, үзвэр үйлчилгээ; 2. Хурим найр, цайллага, хүлээн авалт; 3. Агаар салхинд гарах (Зөвхөн гэр бүлийн гишүүдийн хүрээнд зөвшөөрөх); 4. Цахилгаан шатанд 3-аас илүү хүн суух; 5. Айлд зочлох, зочин урих; 6. Оршуулгын ажилд оролцох (автомашин 8, иргэн 20-оос дээш хязгаарлах); 7. Хуулийн этгээдийн хязгаарлах үйл ажиллагаа /4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18/-нд заасан үйл ажиллагаанууд.	1. Эмнэлгийн зайлшгүй тусламж, эмийн сангаар үйлчлүүлэх; 2. Өмгөөлөл, нотариат; 3. Хүнс, ахуйн хэрэглээний бараа, түлш, зөөврийн ус авах (оршин суугаа хорооны хүнсний дэлгүүр, борлуулалтын цэг, худгаас); 4. Оршуулгын ажилд оролцох (автомашин 5, иргэн 10 хүртэл); 5. Газар тариалан (тусгаарлалтын болон халдвар хамгааллын дэглэм сахих).	
Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага					
Зорчих хөдөлгөөн, үйлчилгээ авах	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм)	-Иргэд хувийн халдвар, хамгааллын дэглэм сахих үйлчилгээ авах; -“QR” код уншуулах; -Хүн хоорондын зай барих.			-Өрхийн нэг гишүүн зөвшөөрсөн үйлчилгээг гэрт хамгийн ойр цэгээс авах; -“QR” код уншуулах; -Оршуулгын үйл ажиллагаанд зөвхөн гэр бүл,

горим	сахих)		хамаатан, садны хүмүүс оролцох.
Автомашинаар зорчих	Автомашинны улсын дугаарын хязгаарлалтын дагуу зорчих (зөвхөн нийслэлд)	06:00-22:00 (Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар автомашин замын оролцох хөдөлгөөнд зохицуулалт хийнэ)	-Эмнэлгийн тусламж үйлчилгээ зайлшгүй авах шаардлагатай тохиолдолд (эмнэлгийн тодорхойлолттой, өвчний онош, хавдар, диализ, жирэмсэн, гэмтэл бэртэл, яаралтай мэс засал гэх мэт); -Оршуулгын үйл ажиллагаа.
Хот дотор нийтийн тээврээр зорчих	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	-Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд зорчихгүй байх; -1 суудал алгасч 1 зорчигч суух; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Хот хоорондын нийтийн тээврээр зорчих	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Халдвар хамгааллын дэглэм сахих.	-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягтай зорчих; -Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай зорчих; -1 суудал алгасч суух; -Хүн хоорондын зай барих; -Халдвар хамгааллын дэглэм сахих.
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтрэх	Хэвийн (халдвар хамгааллын дэглэм сахих)	Шардлагатай тохиолдолд асуумж өгч зорчих; -1 суудал алгасч 1 зорчигч суух; -Халдвар хамгааллын дэглэм сахих.	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.
	Шардлагатай тохиолдолд асуумж өгч нэвтрэх	-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, оршуулгын үйл ажиллагаанд оролцож байгаа холбогдох бичиг баримттай нэвтрэх; -Товчооны гадна ажиллаж, амьдардаг хүн байнга оршин суугаа газрын баг, хорооны тодорхойлолттой нэвтрэх; -Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох	-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягтай нэвтрэх; -Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай нэвтрэх; -Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх.

		бичиг баримттай нэвтрэх.	Эрх бүхий байгууллагаас хязгаарлалт тогтоосон үед Улсын онцгой комиссын даргын тушаалаар баталсан "Хот болон орон нутаг хооронд зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам"-аар зохицуулна.
<p>Зөвлөмж</p> <p>Халдвар хамгааллын дэглэм сахих</p>	<p>-Шаардлагагүй тохиолдолд гэрээс гарахгүй; -Амны хаалт байнга зүүх; -Хүн хооронд 2 метрээс доошгүй зай барих; -Гараа сайтар савандаж угааж, халдваргүйжүүлж хэвших; -Олон нийтийн газар аль болох очихгүй байх; -Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах; -Төрөөс зохион байгуулж байгаа халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд оролцох; -Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр утсаар зөвлөгөө авах.</p>	<p>-Нэн шаардлагатай хүнс, эм, түлш, ус худалдан авахаар айл, өрхөөс 1 хүн гарах; -Айлд зочлохгүй, зочин урихгүй; -Шаардлагагүй тохиолдолд гэрээс гарахгүй; -Амны хаалт байнга зүүх; -Хүн хооронд 2 метрээс доошгүй зай барих; -Гараа сайтар савандаж угааж, халдваргүйжүүлж хэвших; -Олон нийтийн газар аль болох очихгүй байх; -Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах; -Төрөөс зохион байгуулж байгаа халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; -Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр утсаар зөвлөгөө авах.</p>	<p>-Нэн шаардлагатай хүнс, эм, түлш, ус худалдан авахаар айл, өрхөөс 1 хүн гарах; -Айлд зочлохгүй, зочин урихгүй; -Шаардлагагүй тохиолдолд гэрээс гарахгүй; -Амны хаалт байнга зүүх; -Хүн хооронд 2 метрээс доошгүй зай барих; -Гараа сайтар савандаж угааж, халдваргүйжүүлж хэвших; -Олон нийтийн газар аль болох очихгүй байх; -Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах; -Төрөөс зохион байгуулж байгаа халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; -Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр утсаар зөвлөгөө авах.</p>
	<p>1.Коронавируст халдварын өртөлтийн эрсдэлийг эрт мэдээллэх системд холбогдсон байх. 2.Коронавируст (Ковид-19) халдварын эсрэг дархлаажуулалтын бүрэн тун авсанаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн нотлох баримт, Коронавируст (Ковид-19) халдвараар өвчилж эдгэсэн эрүүл мэндийн байгууллагын магадлагааг цахим болон цаасан хэлбэрээр авч явах. 3.Дархлаажуулалтын тухай хуулийн 6.2.1-т "Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шаардлагын дагуу сэргийлэх тарилга хийлгэх үүрэг хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлэх.</p>		

Жич: 1. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд тус журмын 3.3, 3.4, 4.3 дэх заалтыг үндэслэн Улсын онцгой комиссоос тогтоосон түвшиндээ төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны горим, хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлагад зарим өөрчлөлт (тухайлбал: эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний дүн, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, дархлаажуулалтын хамрагдалт, үр дүнг харгалзан төрийн болон хуулийн этгээдийн үйл ажиллагааг үе шаттай нээх, хүний тоо, цагийн зохицуулалт, тээврийн хэрэгслийн болон хот хоорондын хөдөлгөөнд өөрчлөлт хийх гэх мэт) зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж болно.

2. Уулзалт, хурал, цуглааныг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжгүй тохиолдолд байр, танхимд хүний тоог 30-аас хэтрүүлэхгүйгээр, хүн хоорондын зай 2 метрээс доошгүй байхаар зохион байгуулж болно.